

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны .... сарын  
.....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

Монгол улсын 2021 оны сүүлийн хагас, 2022 оны эхний хагас жилд  
импортлох хуурай сүүний тоо хэмжээг тогтоох тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын ...-ны өдрийн хуралдааны ... дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2021 оны сүүлийн хагас, 2022 оны эхний хагас жилд импортлох хуурай сүүний тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
2. Стратегийн хүнсийг импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Л.Чой-Иш)-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д тус тус даалгасугай.
3. Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

Гарын үсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2021 оны .. дугаар сарын .. -ны өдрийн .. дугаар  
тушаалын хавсралт

2021 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС, 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ИМПОРТЛОХ ХУУРАЙ  
СҮҮНИЙ ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Хуурай сүү	Хуурай сүү	0402.21.10	4000 тн (дөрвөн мянга)
			0402.10.00	

